ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 21 өдөр                Дугаар А/09                Мандалговь

## "Цодгор хүү- 2020" улсын аварга шалгалгаруулах шатрын тэмцээнд оролцуулах тухай

Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг түгээн дэлгэрүүлэх, авьяас билгийг нээн хөгжүүлэх зорилгоор аймгаас шалгарсан хүүхдүүдийг "Цодгор хүү - 2020" улсын аварга шалгаруулах шатрын тэмцээнд 2020 оны 01 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд оролцуулсугай.
2. Үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. “Цодгор хүү - 2020” шатрын тэмцээн зохион байгуулахад шаардагдах 542900 (Таван зуун дөчин хоёр мянга есөн зуу) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Залуучуудын хөгжлийн төвийн ажлын албаны нарийн бичиг, ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат), гишүүдэд үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат)-д даалгасугай.

ДАРГА                Ц. ГАНЗОРИГ

9034137 4310129115

431190010